



НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН  
ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД

МОНГОЛ УЛС  
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7, 1 дүгээр хороо,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0035  
Утас: (976-11) 32-71-99, Факс: (976-11) 32-21-47  
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

0022.03.04 № 02-03/952

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Чиглэл хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 63 дугаар хуралдааны тэмдэглэлийн дагуу Нийслэл Улаанбаатар хотын авто замын ачааллыг бууруулах зорилтын хүрээнд төрийн болон төрийн бус өмчийн зарим ерөнхий боловсролын сургуулийн хичээл эхлэх цагийн хуваарийг өөрчилсөн Нийслэлийн Засаг даргын 2022 оны "Нийслэлийн зарим ерөнхий боловсролын сургуулийн хичээл эхлэх цагт зохицуулалт хийх тухай" А/217 дугаар захирамж батлагдан 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрөөс хэрэгжиж эхлээд байна.

Тус захирамжийн 3-т "энэ захирамж гарсантай холбогдуулан хүүхэд нь ерөнхий боловсролын сургуульд суралцдаг ажилтныхаа ажиллах цагийн хуваарьт уян хатан зохицуулалт хийхийг нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг, холбогдох аж ахуйн нэгж, байгууллагуудад зөвлөсүгэй" гэж заасны дагуу ажилтан, албан хаагчдынхаа санал, хүсэлтийг үндэслэн тухайн ажилтны ажиллах цагийн хуваарьт уян хатан зохицуулалт хийж бусад аж ахуйн нэгж, байгууллагуудад манлайлал үзүүлж ажиллана уу.

Хавсралт 3 хуудастай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
НИЙГМИЙН ХӨГЖИЛ, БОЛОВСРОЛ,  
ЭРҮҮЛ МЭНДИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН  
ОРЛОГЧ



З.ТӨМӨРТӨМӨӨ



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 4217

Улаанбаатар хот

Нийслэлийн зарим ерөнхий боловсролын сургуулийн хичээл эхлэх цагт зохицуулалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.8 дахь заалт, 22.5 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны 63 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэл Улаанбаатар хотын авто замын ачааллыг бууруулах зорилтын хүрээнд төрийн болон төрийн бус өмчийн зарим ерөнхий боловсролын сургуулийн хичээл эхлэх цагийн хуваарийг хавсралт ёсоор тогтоосугай.

2. Энэ захирамжийн 1 дүгээр зүйлд заасан цагийн хуваарийг 2021-2022 оны хичээлийн жил дуустал мөрдөж ажиллахыг хавсралтад заасан сургуулийн захирал, үүсгэн байгуулагч нарт үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан хүүхэд нь ерөнхий боловсролын сургуульд суралцдаг ажилтныхаа ажиллах цагийн хуваарьт уян хатан зохицуулалт хийхийг нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг, холбогдох аж ахуйн нэгж, байгууллагуудад зөвлөсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар (Б.Батшагай), Нийслэлийн Боловсролын газар (Ж.Гантулга)-т болон харьяа дүүргийн Засаг дарга нарт, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Нийгмийн хөгжил, боловсрол, эрүүл мэндийн асуудал хариуцсан орлогч З.Төмөртөмөөд тус тус даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР

111020001230

Нийслэлийн Засаг даргын 2022 оны  
 02 дугаар сарын 18-ны өдрийн  
 А/244 дугаар захирамжийн  
 хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЗАРИМ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
 ХИЧЭЭЛ ЭХЛЭХ ЦАГИЙН ХУВААРЬ

№	ДҮҮРЭГ	БҮС	СУРГУУЛЬ	I ЭЭЛЖ		II ЭЭЛЖ	
<b>ТӨРИЙН ӨМЧИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ</b>							
1	БЗД	БҮС - I	21-р сургууль		8:15		13:45
2	БЗД		84-р сургууль	7:45		13:15	
3	БЗД	БҮС - II	33-р сургууль	7:45		13:15	
4	БЗД		48-р сургууль		8:15		13:45
5	СБД	БҮС - I	1-р сургууль	7:45		13:15	
6	СБД		ӨЗБЛАСургууль		8:15		13:45
7	СБД	БҮС - II	31-р сургууль	7:45		13:15	
8	СБД		6-р сургууль		8:15		13:45
9	СБД	БҮС - III	45-р сургууль	7:45		13:15	
10	СБД		11-р сургууль		9:00		
11	СБД	БҮС - IV	Байгаль эх сургууль		8:15		13:45
12	СБД		2-р сургууль	7:45		13:15	
13	СБД		Монгол Консерватори	Улсын	7:45		13:15
14	СБД	БҮС - V	МУБИС - ЕБС	7:45		13:15	
15	ЧД	БҮС - I	5-р сургууль	7:45		13:15	
16	ЧД		50-р сургууль		8:15		13:45
17	ЧД	БҮС - II	23-р сургууль	7:45		13:15	
18	ЧД		24-р сургууль		8:15		13:45
19	ХУД	БҮС - I	18-р сургууль	7:45		13:15	
20	ХУД		15-р сургууль		8:15		13:45
21	ХУД	БҮС - II	52-р сургууль	7:45		13:15	
22	ХУД		75-р сургууль		8:15		13:45
23	ХУД	БҮС-III	130-р сургууль	7:45		13:15	
<b>НИЙТ</b>				14	9	14	9

**ТӨРИЙН БУС ӨМЧИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ**

№	ДҮҮРЭГ	БҮС	СУРГУУЛЬ	I ЭЭЛЖ		II ЭЭЛЖ	
1	БЗД	БҮС - I	И-Эс-Эм	7:45		13:15	
2	БЗД		Кириллица		9:00		
3	БЗД	БҮС - II	Оюунлаг	7:45		13:15	

4	БЗД		Уудам монгол			9:00		
5	БЗД	БҮС - III	Шинэ монгол	7:45			13:15	
6	БЗД		Төгсдэлгэрэх		8:15			13:45
7	БЗД	БҮС - IV	Шилдэг			9:00		
8	БЗД		Их засаг лицей				9:00	
9	БЗД	БҮС - V	Эрхэм баян эрдэм			9:00		
10	БЗД		Гёте	7:45				13:15
11	БЗД	БҮС - VI	Оюуны-Онъс			9:00		
12	СБД	БҮС - I	Логарифм	7:45			13:15	
13	СБД		Үй цай		8:15			13:45
14	СБД	БҮС - II	Сант	7:45			13:15	
15	СБД		Улаанбаатар элит		8:15			13:45
16	СБД	БҮС - III	Шинэ үе		8:15			13:45
17	СБД	БҮС - IV	Эрдэмтөгс			9:00		
18	СБД		Сэлбэ				9:00	
19	СБД	БҮС - V	Дойче шуле			9:00		
20	СБД		Кинг кидс		8:15			13:45
21	СБД	БҮС - V	Эрдмийн уурхай			9:00		
22	СБД		Хаан эрдэм				9:00	
23	ЧД	БҮС - I	Тусгал			9:00		
24	ЧД		Олонлог				9:00	
25	ЧД	БҮС - II	Оюут		8:15			13:45
26	ЧД		Олонлог эгзэ	7:45			13:15	
27	ХУД	БҮС - I	Орчлон сургууль			9:00		
28	ХУД		Хобби сургууль				9:00	
29	ХУД	БҮС - II	Оргил сургууль			9:00		
30	ХУД		Монгол билиг оюун сургууль				9:00	
31	ХУД	БҮС- III	Орхон Хасу сургууль			9:00		
32	ХУД	БҮС - IV	Шинэ Монгол Харумафүжи сургууль	7:45			13:15	
33	ХУД		Бритиш сургууль				9:00	
34	ХУД	БҮС - V	Сакура сургууль			9:00		
35	ХУД		Солонго Эс Эф сургууль				9:00	
36	ХУД	БҮС - VI	Жет тэмүүлэл сургууль			9:00		
НИЙТ				8	6	22	8	6

Жич: Хавсралтад зааснаас бусад ерөнхий боловсролын сургуулийн хичээл эхлэх цаг Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/105 дугаар захирамжийн дагуу 08:00 цагт байна.

----oo0oo----